



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 406

Улаанбаатар хот

**С.Бат-Эрдэнийг ажлаас чөлөөлөх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1 дэх заалт, “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал С.Бат-Эрдэнэтэй байгуулсан 2022 оны 2022/18/к дугаартай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 4.6.1, 5.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал С.Бат-Эрдэнийн хүсэлтийг харгалзан 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосугай.

2.Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсонтой холбогдуулан С.Бат-Эрдэнэд хоёр сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгохыг “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын нягтлан бодогч Ц.Дашдуламд даалгасугай.

3.“Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын ажлыг 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн дотор зохих журмын дагуу хүлээлцүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ